

МОНГОЛ, ЯПОНЫ ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

1. Талууд Монгол, Японы харилцаа 1996 онд тунхагласан Иж бүрэн түншлэлийн зарчмын дор амжилттай хөгжиж ирсэнд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлээд Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболдын 2006 оны гуравдугаар сард Япон Улсад хийсэн айлчлал, Япон Улсын Ерөнхий сайд Ж.Койзүмигийн 2006 оны наймдугаар сард Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр хоёр орны харилцааг шинэ шатанд гаргахаар тохиролцсоны дагуу “Монгол, Японы Хамтын ажиллагааны арван жилийн Үндсэн хөтөлбөр”-ийг үзэглэв. Энэхүү хамтын ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүргэхээ санал нэгтэй илэрхийлэв.

2. Талууд Их Монгол Улс байгуулсны 800 жилийн ойг 2006 онд Япон Улсад “Монголын жил” болгон тэмдэглэсэн, энэ жил Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойг Монгол Улсад “Японы жил” болгон тэмдэглэж байгаа нь хоёр орны харилцааны найрсаг уур амьсгал, Монгол, Японы ард түмний харилцан ойлголцол, итгэлцлийг улам бэхжүүлэхэд тус болж байгааг үнэлэв. Ерөнхий сайд Ш.Абэ Япон Улсын Засгийн газрын “21-р зууны Зүүн Азийн хүүхэд, залуусын солилцооны их хөтөлбөр”-ийн дагуу ирэх таван жилийн хугацаанд Монголын дунд сургуулийн ахлах ангийн сурагчид зонхилсон 100 хүртэл хүүхдийг жил бүр Японд урьж зочлуулахаа мэдэгдлээ.

3. Ерөнхийлөгч Н.Энхбаяр Монгол Улсад ардчилал бэхжин, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих үе үндсэндээ дуусч, тогтвортой хөгжлийн шинэ шат эхэлж байгааг мэдээлээд түүнд Япон Улсын дэмжлэг, тусламж дорвитой хувь нэмэр оруулж ирснийг өндөр үнэлж, талархал илэрхийлэв.

Ерөнхий сайд Ш.Абэ, Монгол Улс ардчилал, бие даасан хөгжлийнхөө төлөө гаргаж байгаа хүч чармайлтыг Япон Улс цаашид ч дэмжинэ гэдгийг нотлов. Үүнтэй холбогдуулж Японы тал Монгол Улсын Засгийн газрын зүгээс хүсэлт болгож буй иений хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Улаанбаатар хотод нисэх онгоцны шинэ буудал барих” төслийг эдүгээ хийж байгаа судалгааны дүнд үндэслэн идэвхтэй дэмжихээ мэдэгдлээ.

Мөн Японы тал буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх “Улаанбаатар хотын Энгельсийн гудамжинд гүүрэн гарц барих” төслийг хэрэгжүүлэх чиглэлээр Монголын талтай хамтарч ажиллана гэв. Түүнчилэн Улаанбаатар хотын агаарын бохирдлыг багасгах талаар хамтран ажиллах боломжийг Монголын талтай хамтран судлах хүсэлтэй байгаа.

Японы тал буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх “Боловсон хүчин бэлтгэх хөтөлбөр”, “Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн төсөл”, “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын өргөтгөл төсөл”-ийг 2007 онд хэрэгжүүлэх чиглэлээр Монголын талтай хамтарч ажиллана гэлээ. Японы тал техникийн чиглэлээр сургаж байгаа монгол залуусын тоог 2007 оноос хоёр дахин өсгөхөө илэрхийллээ.

4. Талууд Монгол Улс, Япон Улсын хооронд улс төрийн яриа хэлцээ өндөр түвшинд хүрч, харилцан ойлголцол, итгэмжилсэн байдал бэхжиж байгаад сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлээд үүнийг цаашид үргэлжлүүлэх нь чухал гэж үзэж байгаагаа тэмдэглэлээ. Ерөнхийлөгч Н.Энхбаяр Ерөнхий сайд Ш.Абэ-г хоёр талын тааламжтай үед Монгол Улсад айлчлахыг урилаа. Ерөнхийлөгч Н.Энхбаяр Япон Улсын Эрхэм дээд Хунтайж Нарухито, Эрхэм дээд гүнж Масако, Парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Ё.Коно, Зөвлөхүүдийн Танхимын дарга Ч.Оги нарыг 2007 онд Монгол Улс дахь “Японы жил”-ийн хүндэт зочноор Монгол Улсад айлчлахыг урив.

5. Хоёр тал Монгол, Японы хамтын ажиллагааны механизмыг илүү тодорхой, оновчтой болгох нь зүйтэй гэж үзэж, хоёр орны холбогдох яамдын хооронд эхэлсэн зөвлөлдөх уулзалтуудыг өргөтгөн бэхжүүлэхээр тохиров. Мөн хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх ая таатай нөхцлийг бүрдүүлэх нь чухал байгааг тэмдэглэв. Монголын тал Японы томоохон компаниуд Монголын уул уурхайн салбарт хөрөнгө оруулахыг сонирхож байгаад баяр хүргээд холбогдох эрх зүйн зохицуулалтын хүрээнд Японы компаниудтай хэлэлцээ эхлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ гэлээ.

6. Монголын тал Монгол Улсын 2021 он хүртэлх “Үндэсний хөгжлийн цогц хөтөлбөр” боловсруулж дуусч байгаагаа мэдээлээд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Япон Улсын Засгийн газар Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд хоёр орны эрдэмтэд, судлаачдын багийн хүчээр боловсруулах санал тавив. Японы тал Монгол Улс хөгжлийн цогц хөтөлбөрөө чухалчилж байгааг бүрэн дүүрэн ойлгож, Монголын талын саналыг судалж үзэхээ мэдэгдэв.

7. Монголын тал Япон Улсын Засгийн газрын “Хөгжлийн санаачлага” хөтөлбөрийн хүрээнд Монголын экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэрлэлт, борлуулалтад туслахыг хүслээ.

8. Талууд хоёр орны хувийн хэвшлийнхний эдийн засгийн хамтын ажиллагааг урагшлуулах таатай нөхцлийн нэг гэж үзэж Монголын талаас санал болгож ирсэн Давхар татвараас харилцан чөлөөлөх тухай хэлэлцээр байгуулах асуудлаар энэ онд багтаан санал солилцож эхлэхээр тохиров.

9. Талууд 21-р зууны сорилтууд, хүний аюулгүй байдалд заналхийлсэн төвөгтэй асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай байгааг дахин нотлов. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын бус гишүүний 2008 оны сонгуульд Япон Улс нэрээ дэвшүүлэхийг Монгол Улс дэмжихээр шийдвэрлэсэн найрсаг, сайн санааны онцгой алхамд Японы тал талархаж байгаагаа дахин илэрхийллээ.

10. Японы тал олон улсын болон бүс нутгийн байгууллагуудад Монгол Улс нэгдэн орохтой холбогдуулж мэдээлэл өгөх, санал солилцох, зөвлөлгөө өгөх зэргээр дэмжлэг үзүүлэхээ мэдэгдэв.

11. Талууд Умард Солонгосын цөмийн асуудлаарх зургаан талт хэлэлцээний тав дахь удаагийн уулзалтын гуравдугаар хуралдааны үеэр Умард Солонгос тодорхой амлалт авч, Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангижруулахад чиглэсэн тодорхой ажиллагаа эхэлсэн нь нэг ахиц гэж үзэж, авсан амлалтаа даруй биелүүлэхийн зэрэгцээ НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн 1718 тоот тогтоолыг бүрэн хэрэгжүүлэх бодитой, үр дүнтэй арга хэмжээ авахыг Умард Солонгост уриалав.